ХУДАЛДААНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилго

1.1.Энэ хуулийн зорилго нь худалдааг төрөөс зохицуулах замаар эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжиж, үндэсний аюулгүй байдлыг хангахад оршино.

2 дугаар зүйл.Худалдааны тухай хууль тогтоомж

2.1.Худалдааны тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар бараа, үйлчилгээний худалдааг зохицуулна.

3.2.Энэ хуулиар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах харилцааг зохицуулахгүй.

3.3.Энэ хуулиар төрийн байгууллагын эзэмшиж, эсхүл тэдгээрийн нэрийн өмнөөс боловсруулж буй өгөгдөл, мэдээлэл, үйлчилгээний харилцааг зохицуулахгүй.

3.4.Худалдаатай холбогдох энэ хуулиар зохицуулаагүй харилцааг холбогдох бусад хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“барааны худалдаа” гэж бараг худалдан авах, худалдах, нийлүүлэх, түгээх болон хэрэглэгчид хүргэхтэй холбоотой бөөний болон жижиглэн худалдааны аж ахуйн үйл ажиллагааг;

4.1.2.“бөөний худалдаа” гэж цаашид дахин худалдах, эсхүл хувийн, гэр бүлийн, ахуйн болон түүнтэй адил хэрэгцээнээс бусад зорилгоор ашиглахад зориулан бараа худалдахыг;

4.1.3.“гадаад худалдаа” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа, үйлчилгээ экспортлох, импортлох үйл ажиллагааг;

4.1.4.“гадаадын хөрөнгө оруулалттай жижиглэн худалдааны этгээд” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, хувь нийлүүлсэн хөрөнгийн тодорхой хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа хуулийн этгээдийг;

4.1.5.“демпинг” гэж гадаад улсаас импортолж буй бараг экспортлогч улсын дотоодын зах зээл дэх ижил төрлийн барааны хэвийн үнээс нь доогуур үнээр Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдахыг;

4.1.5 “дэнчин” гэж Иргэний хуулийн 233.1.-д заасныг;

4.1.6.“импорт” гэж Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт гадаад улсын гаалийн нутаг дэвсгэрээс бараа оруулахыг;

DRAFT

4.1.7.“импортыг орлох, экспортыг дэмжих салбар, үйл ажиллагаа, төслийн жагсаалт” гэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.15-д заасны дагуу тогтоосон бараа, үйлчилгээг;

4.1.8.“импортын огцом өсөлт” гэж ижил төрлийн эсхүл шууд өрсөлдөх барааны импортын хэмжээ, зах зээлд эзлэх хувь мэдэгдэхүйц нэмэгдэж, дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учирсан, эсхүл учрах бодит аюул бий болсон нөхцөл байдлыг;

4.1.9.“квот” гэж эрх бүхий байгууллагаас Монгол улсын гаалийн нутаг дэвсгэрээс экспортлох, импортлох барааны тоо, хэмжээ, нийт үнийн дүнг хязгаарлах арга хэмжээг;

4.1.10.“жижиглэн худалдаа” гэж худалдан авагчид хувийн, гэр бүлийн, ахуйн болон үүнтэй адил бусад хэрэгцээнд зориулан бараа, бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагааг;

4.1.11.“мэдээллийн систем” гэж Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 4.1.1-д заасныг;

4.1.12.“мэдээллийн сүлжээ” гэж Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 4.1.2-т заасныг;

4.1.15.“тарифын арга хэмжээ” гэж барааг импортлох, эсхүл экспортлоход гаалийн татвар ногдуулах замаар гадаад худалдааг зохицуулахыг;

4.1.16.“тарифын квот” гэж тогтоосон квотын хүрээнд импортлох бараанд гаалийн татварын бууруулсан хувь хэмжээг, квотоос давсан хэмжээний бараанд гаалийн татварын өндөр хувь хэмжээг ногдуулах арга хэмжээг;

4.1.18.“татаас” гэж гадаад улсын засгийн газар, төрийн байгууллагаас тодорхой этгээд, салбар, бараанд шууд болон шууд бусаар олгосон санхүүгийн дэмжлэг, үнийн дэмжлэг, татварын хөнгөлөлт болон түүнтэй адилтгах дэмжлэгийг;

4.1.19.“үйлчилгээний худалдаа” гэж үйлчилгээ үзүүлэх, гүйцэтгэх, нийлүүлэхтэй холбоотой аж ахуйн үйл ажиллагааг;

4.1.20.“үйлчилгээний нөхцөл” гэж цахим худалдааны платформын хүрээнд бараа, үйлчилгээ худалдах, худалдан авах ажиллагааг гүйцэтгэх нөхцөл, журам, аргачлал, талуудын эрх, үүрэг, хариуцлага, төлбөр тооцоо, шимтгэл, хүргэлт, буцаалт, гэрээ цуцлах, гомдол болон маргаан шийдвэрлэх журмыг тодорхойлсон, цахим худалдааны платформ эрхлэгчийн баталсан баримт бичгийг/стандарт гэрээг;

4.1.21.“худалдаа эрхлэгч” гэж худалдаа эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийг;

4.1.23.“цахим худалдаа” гэж интернет болон бусад мэдээллийн сүлжээгээр дамжуулан бараа худалдах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг;

4.1.24.“цахим худалдааны платформ” гэж гуравдагч этгээдэд худалдаа эрхлэх орчныг бүрдүүлж, мэдээлэл нийтэлж, худалдаа, үйлчилгээ зуучилдаг цахим системийг;

4.1.25.“цахим худалдаа эрхлэгч” гэж интернет болон бусад мэдээллийн сүлжээгээр дамжуулан бараа худалдаж, үйлчилгээ үзүүлж буй хүн, хуулийн этгээдийг;

4.1.26.“цахим худалдааны платформ эрхлэгч” гэж цахим худалдааны хүрээнд хоёр болон түүнээс дээш этгээдэд цахим худалдааны платформын үйлчилгээ үзүүлж буй иргэн, хуулийн этгээдийг;

4.1.27.“цахим худалдааны платформоор дамжуулан худалдаа эрхлэгч” гэж цахим худалдааны платформоор дамжуулан бараа худалдаж, үйлчилгээ үзүүлж буй иргэн, хуулийн этгээдийг;

4.1.28.“цахим гарын үсэг” гэж Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.10-д заасныг;

4.1.29.“Гадаад худалдааны цахим нэг цонх” /цаашид “цахим нэг цонх” гэх/ гэж импорт, экспорт, дамжин өнгөрөхтэй холбоотой зөвшөөрөл, мэдүүлэг, баримт бичиг, мэдээллийг нэг удаа, нэг цэгээр, цахимаар ирүүлэх замаар төрийн эрх бүхий байгууллагуудын хооронд харилцан ажиллагааг хангах төрийн нэгдсэн автоматжуулсан мэдээллийн системийг;

4.1.30.“шударга бус худалдааны үйл ажиллагаа” гэж дотоодын үйлдвэрлэлд хохирол учруулах, эсхүл учруулах бодит эрсдэл бий болгосон демпинг, татаастай худалдааны үйл ажиллагаа, импортын огцом өсөлтөөс үүдэн хамгаалалтын арга хэмжээ авах шаардлага бий болсон нөхцөл дараах үйл ажиллагааг;

4.1.31.“экспорт” гэж Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрээс гадаад улсын нутаг дэвсгэрт бараа, үйлчилгээг гаргахыг;

4.1.32.“экспортын бараа үйлдвэрлэгч” гэж энэ хуулийн 4.1.24-т заасан бараа үйлдвэрлэгч иргэн, хуулийн этгээдийг;

4.2.Энэ хуулийн 4.1-д зааснаас бусад нэр томьёог Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу ойлгоно.

5 дугаар зүйл.Худалдааны зохицуулалтын зарчим

5.1.Төрөөс худалдааг хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

5.2.Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжоор хориглосон, хязгаарласнаас бусад тохиолдолд худалдааг чөлөөтэй эрхэлж болно.

5.3.Худалдаа эрхлэгч тухайн бараа, үйлчилгээнд хамаарах хууль тогтоомжид заасан зөвшөөрөл болон бусад нөхцөл, шаардлагыг хангана.

5.4.Хэрэв аль нэг улс, эсхүл бүс нутаг Монгол Улсын эсрэг хориглосон, хязгаарласан, ялгаварлан гадуурхсан, эсхүл түүнтэй төстэй арга хэмжээ авсан тохиолдолд Монгол Улс тухайн нөхцөл байдлыг харгалзан холбогдох хариу арга хэмжээ авч болно.

5.5.Худалдааны зохицуулалтад дараах зарчмыг баримтална:

5.5.1.үндэсний аюулгүй байдлыг хангах;

5.5.2.ил тод байдлыг хангах;

5.5.3.Монгол Улсын олон улсын гэрээ, хуульд зааснаас бусад тохиолдолд үл ялгаварлах;

5.5.4.худалдаа эрхлэгч, хэрэглэгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах;

5.5.5.дотоодын үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дэмжих, хамгаалах.

5.6.Энэ хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актад заасан худалдааны хязгаарлалтыг хэрэглэхдээ уг хязгаарлалтыг түүний зорилгыг биелүүлэхэд шаардлагатай хамгийн бага хэмжээнд тогтоож, хэрэгжүүлнэ.

DRAFT

5.7.Хууль тогтоомжийн төсөл бараа, үйлчилгээ худалдааг хязгаарлах үр дагаврыг бий болгохоор бол эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулахаар хүргүүлнэ.

5.8.Эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газрын санаачлах хууль тогтоомжийн төсөл худалдааг хязгаарлах эсэхийг хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАДААД ХУДАЛДАА

6 дугаар зүйл.Гаалийн тарифын зөвлөл

6.1.Гаалийн тарифыг өөрчлөх үндэслэл, шаардлагын талаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн Гаалийн тарифын орон тооны бус зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ Худалдааны зөвлөлийн дэргэд ажиллана.

6.2.Зөвлөлийн дарга эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

6.3.Зөвлөлийн ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохицуулах үүрэг бүхий нарийн бичгийн дарга орон тооны байна.

6.4.Зөвлөл нь мэргэжлийн салбар зөвлөл, шинжээчдийн багтай байж болно.

6.5.Эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Зөвлөлийн дүрэм, ажиллах журмыг баталж, бүрэлдэхүүнийг томилж, чөлөөлнө.

6.6.Зөвлөл үйл ажиллагаандаа бие даасан, ил тод байх, хараат бус, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, хамтын удирдлагын зарчмаар асуудлыг чөлөөтэй хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэх зарчмыг удирдлага болгоно.

7 дугаар зүйл.Тарифын арга хэмжээ

7.1.Тарифын арга хэмжээг Монгол Улсын олон улсын гэрээ, энэ хууль болон Гаалийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн хэрэглэнэ.

7.2.Зөвлөл гаалийн тариф нь энэ хуулийн зорилго, зарчим, нөхцөл, шаардлагад нийцэж байгаа эсэх талаар дор дурдсан шалгуур үзүүлэлтийн дагуу хоёр жил тутамд хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ:

7.2.1.Монгол Улсын эдийн засаг, төсвийн орлогод үзүүлэх нөлөө;

7.2.2.дотоодын үйлдвэрлэлд үзүүлэх нөлөө;

7.2.3.үнэ, инфляц, өрхийн амьжиргаа, нийлүүлэлтийн сүлжээ, өрсөлдөх чадварт үзүүлэх нөлөө;

7.2.4.гаалийн бүрдүүлэлтийн хугацаа, зардалд үзүүлэх нөлөө;

7.2.5.барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем болон тариф хэрэглэх аргачлалын тодорхой байдал;

7.2.6.Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, амлалтад нийцэж байгаа байдал.

7.3.Энэ хуулийн 7.2-т заасан хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүнг олон нийтээр хэлэлцүүлж, саналыг тусгасан байна.

DRAFT

7.4.Зөвлөл энэ хуулийн 7.2-т заасан хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн тухайн тарифын хувь хэмжээг өөрчлөх, эсхүл хэвээр үлдээх тухай дүгнэлт гаргаж, Худалдааны зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

7.5.Худалдааны зөвлөл Зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, холбогдох зөвлөмж, саналын хамт Засгийн газарт хүргүүлнэ.

7.6.Худалдааны зөвлөлийн ирүүлсэн зөвлөмж, саналыг үндэслэн Засгийн газар гаалийн тарифыг өөрчлөх тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн барина.

7.7.Засгийн газар гаалийн тарифын хувь, хэмжээг дараах тохиолдолд өөрчлөн тогтоож болно:

7.7.1.үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, стратегийн бараа, үйлчилгээний тасралтгүй хангамжийг хамгаалах;

7.7.2.дайн, зэвсэгт мөргөлдөөн, гамшгаас шалтгаалсан хангамжийн ноцтой тасалдал үүссэн;

7.7.3.бараа үнэмлэхүй, эсхүл харьцангуй үзүүлэлтийн хувьд өсөн нэмэгдсэн хэмжээгээр импортлогдож, энэ нь ижил бараа, эсхүл шууд өрсөлдөх барааны дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учруулсан, эсхүл учруулах бодит эрсдэл бий болсон;

7.7.4.демпингийн үнээр бараа импортолж буй нь хянан магадлагаагаар тогтоогдсон;

7.7.5.татаастай бараа импортолж буй нь хянан магадлагаагаар тогтоогдсон;

7.7.6.төлбөрийн тэнцэл алдагдсан;

7.7.7.Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн бусад тохиолдолд;

7.7.8.эдийн засгийн хөгжилд Засгийн газраас тусламж, дэмжлэг үзүүлэх.

7.8.Зөвлөл санхүү, төсвийн асуудал эрхэлсэн, эсхүл эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хүсэлтээр гаалийн тарифын хувь хэмжээг өөрчлөх, эсхүл тарифтай холбоотой бусад асуудлаар дүгнэлт гаргана.

7.9.Тарифын зохицуулалтын талаар энэ хуулиар зохицуулснаас бусад асуудлыг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиар зохицуулна.

7.10.Энэ хуулийн 7.7.3, 7.7.4, 7.7.5, 7.7.6, 7.7.8-д заасан арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бол олон улсын гэрээний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу мэдэгдэх үүрэгтэй.

7.11.Энэ хуулийн 7.7.3, 7.7.4, 7.7.5-д заасан арга хэмжээг энэ хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу хянан магадлагаа явуулсны үндсэн дээр авч хэрэгжүүлнэ.

8 дугаар зүйл.Экспорт, импортыг хориглох, хязгаарлах

8.1.Хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газар экспортлох, импортлохыг хориглох барааны жагсаалтыг Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн дагуу батална.

8.2.Засгийн газар энэ хуулийн 8.1-д заасан барааг тусгай зориулалтаар, (баталгаат засвар, шинжилгээ, туршилт, эрдэм шинжилгээ, эрүүл мэнд, эм үйлдвэрлэл, үндэсний батлан хамгаалах, аюулгүй байдлын зорилгоор) экспортлох, импортлохыг зөвшөөрч болно.

DRAFT

8.3.Засгийн газар энэ хуулийн 8.1-д заасан жагсаалтад хамаарахгүй бараанд үйлчлэх хязгаарлалт, хориглолтыг түр хугацаагаар энэ хуульд заасан журмын дагуу тогтоож болно.

8.4.Энэ хуулийн 8.1-д зааснаас бусад бараа, үйлчилгээний хувьд дараах тохиолдолд хориглох, хязгаарлах арга хэмжээ авч болно:

8.4.1.үндэсний аюулгүй байдал, нийтийн ёс суртахууныг хамгаалах зорилгоор экспорт, импортыг;

8.4.2.хүн, амьтан, ургамлын амьдрал, эсхүл эрүүл мэндийг хамгаалах зорилгоор экспорт, импортыг;

8.4.3.алт, эсхүл мөнгөний экспорт, импортыг;

8.4.4.урлаг, түүх, археологийн үнэт үндэсний өвийг хамгаалах зорилгоор экспорт, импортыг;

8.4.5.шавхагдах байгалийн нөөцийг хамгаалах арга хэмжээ нь дотоодын үйлдвэрлэл, хэрэглээнд тавих хязгаарлалттай хамт хэрэгжиж байгаа нөхцөлд экспорт, импортыг;

8.4.6.засгийн газар хоорондын түүхий эдийн хэлэлцээрийн хүрээнд хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх зорилгоор экспорт, импортыг;

8.4.7.дотоодын боловсруулах үйлдвэрлэлд шаардлагатай тухайн барааны экспортыг;

8.4.8.бараа, бүтээгдэхүүнийг импортолж буй улс орон, бүс нутгийн зах зээлийн хязгаарлагдмал багтаамжтай холбоотой экспортыг;

8.4.9.экспортын үйл ажиллагаатай холбоотой ноцтой төөрөгдөл, эмх замбараагүй байдал бий болсон тохиолдолд экспортыг;

8.4.10.Монгол Улсад аливаа бараа үнэмлэхүй, эсхүл харьцангуй үзүүлэлтийн хувьд өсөн нэмэгдсэн хэмжээгээр импортлогдож, энэ нь ижил бараа, эсхүл шууд өрсөлдөх барааны дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учруулсан, эсхүл учруулах бодит эрсдэл бий болсон тохиолдолд импортыг;

8.4.11.төлбөрийн тэнцлийг хангах зорилгоор импортыг;

8.4.12.хүнсний бүтээгдэхүүн болон бусад нэн шаардлагатай барааны ноцтой хомсдолоос урьдчилан сэргийлэх буюу түүнийг арилгах зорилготой экспортыг;

8.4.13.стандарт буюу холбогдох журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тохиолдолд импорт, экспортыг;

8.4.14.эдийн засгийн хөгжилд үзүүлэх Засгийн газрын тусламж, дэмжлэгийн зорилгоор импорт, экспортыг;

8.4.15.Монгол Улсын олон улсын гэрээ, хуульд заасан бусад.

8.5.Хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газар энэ хуулийн 8.4-т заасан шийдвэрийг эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн гаргана.

DRAFT

9 дүгээр зүйл.Экспорт, импортын квот тогтоох

9.1.Эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн жилд квот тогтоох барааны нэр төрөл, тоо хэмжээний тухай саналыг Засгийн газар хүргүүлнэ.

9.2.Засгийн газар экспорт, импортын квот тогтоох барааны жагсаалтыг Бараг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн дагуу батална.

9.3.Дараах тохиолдолд экспорт, импортын квот тогтооно:

9.3.1.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан;

9.3.2.макро эдийн засгийн тэнцвэр, эдийн засгийн өсөлтийг үе шаттай хангах шаардлагатай бараанд;

9.3.3.импортлогч улс Монгол Улсын экспортын бараанд импортын квот тогтоосон;

9.3.4.хуульд заасан бусад.

9.4.Засгийн газар экспорт, импортын квот тогтоох, квот хуваарилах шалгуур, аргачлал, хуваарилах журмыг батална.

9.5.Экспорт, импортын квотыг бусдад шилжүүлэх, худалдах, барьцаалахыг хориглоно.

10 дугаар зүйл.Тарифын квот тогтоох

10.1.Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу экспорт, импортын тарифын квот тогтооно.

10.2.Импортын тарифын квотыг экспортын бараа үйлдвэрлэх, боловсруулахад ашиглагдах бараанд тогтоохгүй.

10.3.Тарифын квот хэрэглэх бараанд ногдуулах гаалийн тарифын квотын доторх болон квотоос давсан хувь хэмжээг Монгол Улсын олон улсын гэрээ, эсхүл бусад хуульд заасны дагуу тогтооно.

10.4.Засгийн газар тарифын квот тогтоох, хуваарилах шалгуур, аргачлал, хуваарилах журмыг батална.

10.5.Тарифын квотыг бусдад шилжүүлэх, худалдах, барьцаалахыг хориглоно.

11 дүгээр зүйл.Экспорт, импортыг түр зогсоох

11.1.Засгийн газар эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналд үндэслэн дараах тохиолдолд экспорт, импортыг түр зогсоож болно:

11.1.1.яаралтай арга хэмжээ авах шаардлагатай;

11.1.2.хориглох, хязгаарлах барааны жагсаалтад хамаарахгүй боловч энэ хуулийн 8.4-т заасан үндэслэл үүссэн.

11.2.Экспорт, импортыг түр зогсоох арга хэмжээг тогтоосон шийдвэрийн хүчинтэй хугацаа дууссан, эсхүл тухайн бараа энэ хуулийн 11.1-д заасан үндэслэлд хамаарахгүй болсон тохиолдолд уг арга хэмжээг хүчингүй болгоно.

11.3.Засгийн газар тухайн асуудлыг эрхэлсэн сайдын саналыг үндэслэн баталгаат засвар, шинжилгээ, туршилт, эрдэм шинжилгээ, эрүүл мэнд, эм үйлдвэрлэл,

DRAFT

үндэсний батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах зориулалтаар экспорт, импортыг түр зогсоосон барааг экспортлох, импортлохыг зөвшөөрч болно.

12 дугаар зүйл.Яаралтай арга хэмжээ авах

12.1.Дараах тохиолдолд бараанд яаралтай хяналтын арга хэмжээ хэрэглэнэ:

12.1.1.гамшгийн үед Монгол Улсын эрх бүхий байгууллагаас албан ёсоор мэдээлсэн, эсхүл тухайн бараа нь хэрэглэгчдийн эрүүл мэндэд ноцтой аюул учруулах эрсдэлтэй нь нотлогдсон улс, нутаг дэвсгэр, бүс нутгаас гаралтай бараа;

12.1.2.дайн, зэвсэгт мөргөлдөөн явагдаж буй, эсхүл оролцож буй, эсхүл зэвсэгт мөргөлдөөн үүсэх өндөр эрсдэлтэй улс, нутаг дэвсгэр, бүс нутгаас гаралтай бөгөөд Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, нийтийн ёс суртахуунд шууд, эсхүл шууд бусаар нөлөөлөх бараа;

12.1.3.тухайн бараатай холбоотой осол, доголдол, техникийн алдаа гарсныг эрх бүхий байгууллагаас албан ёсоор мэдээлсэн, эсхүл тухайн бараа нь хэрэглэгчдийн эрүүл мэндэд ноцтой аюул учруулах эрсдэлтэй нь нотлогдсон улс, нутаг дэвсгэр, газар зүйн бүс нутгаас гаралтай бараа;

12.1.4.Монгол Улсын байгаль орчин, экологи, биологийн олон янз байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлж байгааг эрх бүхий байгууллагаас албан ёсоор мэдээлсэн, эсхүл шинжлэх ухааны үндэслэлээр нотлогдсон улс, нутаг дэвсгэр, бүс нутгаас гаралтай бараа;

12.1.5.төлбөрийн тэнцлийн ноцтой алдагдал үүссэн тохиолдолд;

12.1.6.хуульд заасан бусад.

12.2.Засгийн газар холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэн яаралтай арга хэмжээ авах шийдвэр гаргана.

12.3.Засгийн газар энэ хуулийн 12.1-т заасан нөхцөл байдал арилсан, эсхүл холбогдох талуудтай зөвлөлдөх, хэлэлцэх замаар тохиролцсон тохиолдолд яаралтай арга хэмжээг хүчингүй болгоно.

13 дугаар зүйл.Экспорт, импортын хилийн боомтыг тогтоох

13.1.Бараа, тээврийн хэрэгслийг Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасны дагуу тогтоосон хилийн боомтоор оруулна.

13.2.Гаалийн нутаг дэвсгэрт зарим нэр төрлийн бараа, тээврийн хэрэгслийг оруулах хилийн боомтыг энэ хууль, холбогдох бусад хуульд заасны дагуу, эсхүл Засгийн газрын шийдвэрээр тогтоож болно.

13.3.Худалдаа эрхлэгч энэ хуулийн 13.1-т заасны дагуу тогтоосон боомтоос барааг импортлох боомтоо чөлөөтэй сонгох эрхтэй.

14 дүгээр зүйл.Зарим барааны экспорт, импортын онцгой эрх

14.1.Үндэсний аюулгүй байдал, нийтийн ёс суртахуун, стратегийн ач холбогдол, эсхүл Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний үүргийн биелэлтийг хангах шаардлагатай тохиолдолд Засгийн газар тодорхой барааны экспорт, импортын үйл ажиллагааг онцгой эрхийн үндсэн дээр хэрэгжүүлэх шийдвэр гаргаж болно.

14.2.Онцгой эрх олгох барааны жагсаалт, эрх эдлэх этгээд, хугацаа, тоо хэмжээ, хэрэгжүүлэх нөхцөл, хяналт тавих журмыг эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

14.3.Энэ хуулийн 14.1–т заасны дагуу олгосон онцгой эрхийг бусдад шилжүүлэх, худалдах, барьцаалахыг хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХУДАЛДААГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

15 дугаар зүйл.Шударга бус үйл ажиллагааг хянан магадлах

15.1.Худалдааны зөвлөл дараах шударга бус худалдааны үйл ажиллагааг хянан магадлана:

15.1.1.демпингийн улмаас ижил төрлийн барааны дотоодын үйлдвэрлэлд хохирол учирсан, эсхүл учрах аюул бий болсон эсэх;

15.1.2.татаастай импортын улмаас ижил төрлийн барааны дотоодын үйлдвэрлэлд хохирол учирсан, эсхүл учрах аюул бий болсон эсэх;

15.1.3.импортын огцом өсөлтөөс ижил, эсхүл шууд өрсөлдөх бараа үйлдвэрлэдэг дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учруулсан, эсхүл учруулах эрсдэл бий болсон эсэх.

15.2.Энэ хуулийн 15.1-д заасан шударга бус худалдааны үйл ажиллагаа хянан магадлагаагаар тогтоогдсон тохиолдолд Худалдааны зөвлөл дараах арга хэмжээ авах талаар дүгнэлт, зөвлөмж гаргана:

15.2.1.демпингийн эсрэг татвар ногдуулах;

15.2.2.демпингийн эсрэг үнийн амлалт авах;

15.2.3.демпингийн эсрэг бусад зохицуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх;

15.2.4.татаасын эсрэг татвар ногдуулах;

15.2.5.татаасыг саармагжуулах арга хэмжээ авах;

15.2.6.импортын тоо хэмжээнд хязгаарлалт тогтоох;

15.2.7.тарифын түвшинг түр хугацаагаар нэмэгдүүлэх;

15.2.8.импортын тусгай зөвшөөрлийн горим хэрэгжүүлэх.

16 дугаар зүйл.Худалдааны үйл ажиллагааг хянан магадлах

16.1.Энэ хуулийн 15.1-т заасан хянан магадлагаа хийх журмыг Засгийн газар батална.

16.2.Энэ хуулийн 15.1.1, 15.1.2-т заасан худалдааны үйл ажиллагааг хянан магадлуулах тухай хүсэлтийг хүн, хуулийн этгээд Худалдааны зөвлөлд бичгээр, эсхүл цахимаар гаргаж болно.

16.3.Хянан магадлагааг Худалдааны зөвлөл өөрийн санаачилгаар хийж болно.

16.4.Энэ хуулийн 16.2-т заасан хянан магадлуулах хүсэлтийг хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор хянан магадлагаа эхлүүлэх эсэх тухай шийдвэр гаргана.

DRAFT

16.5.Хянан магадлагааг эхлүүлэх тухай шийдвэр гаргасан өдрөөс хойш 1 жилийн дотор хянан магадлагааг дуусгана. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг 1 удаа 6 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.

16.6.Худалдааны зөвлөл хянан магадлагааны явцад холбогдох этгээдээс мэдээлэл, баримт бичиг гаргуулж, тайлбар авах эрхтэй.

16.7.Холбогдох этгээд хянан магадлагааны хүрээнд үнэн зөв мэдээлэл ирүүлэх үүрэгтэй.

16.8.Худалдааны зөвлөл шаардлагатай гэж үзвэл хянан магадлагааны явцад нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж болно.

16.9.Эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянан магадлагааг эхлүүлэхээр шийдвэрлэсэн бол энэ тухай нийтэд мэдээлж, Дэлхийн Худалдааны Байгууллагын холбогдох хороонд мэдэгдлийг хүргүүлнэ.

16.10.Худалдааны зөвлөлийн хянан магадлагааны дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн холбогдох арга хэмжээ авах тухай саналыг Засгийн газарт хүргүүлнэ.

16.11.Засгийн газар энэ хуулийн 16.10-д заасан саналыг хэлэлцэж демпингийн эсрэг, татаасын эсрэг, хамгаалалтын арга хэмжээг авах эсэх тухай шийдвэр гаргана.

17 дугаар зүйл.Мэдээллийн нууцлал, хамгаалалт

17.1.Хянан магадлагааны явцад ирүүлсэн худалдаа, үйлдвэрлэл, санхүү, үнэ болон бизнесийн бусад нууц мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд задруулахыг хориглоно.

17.2.Худалдааны зөвлөл хянан магадлагаанд ашигласан мэдээллийг зөвхөн тухайн хүсэлтийг шийдвэрлэх, дүгнэлт, зөвлөмж гаргахад ашиглана.

18 дугаар зүйл.Хэрэгжилтийн тайлан, хяналт

18.1.Худалдааны зөвлөл демпингийн эсрэг, татаасын эсрэг, хамгаалалтын арга хэмжээний үр нөлөө, хэрэгжилтийн талаар үнэлгээ хийж, дүгнэлт гаргана.

18.2.Эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 18.1-т заасан үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн арга хэмжээг үргэлжлүүлэх, өөрчлөх, эсхүл цуцлах тухай саналыг Засгийн газарт хүргүүлнэ.

18.3.Засгийн газар энэ хуулийн 18.2-т заасан саналыг хэлэлцэж демпингийн эсрэг, татаасын эсрэг, хамгаалалтын арга хэмжээг үргэлжлүүлэх, өөрчлөх, эсхүл цуцлах тухай шийдвэр гаргана.

19 дүгээр зүйл.Хариу арга хэмжээ

19.1.Засгийн газар дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд бараа, үйлчилгээний худалдаанд хязгаарлалт тогтоох хариу арга хэмжээ авч болно:

19.1.1.тухайн улс Монгол Улстай байгуулсан олон улсын гэрээний үүргээ биелүүлээгүй;

DRAFT

19.1.2.тухайн улс Монгол Улс, эсхүл Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчсөн, зах зээлд нэвтрэх боломжийг үндэслэлгүйгээр хязгаарласан, ялгаварлан гадуурхсан;

19.1.3.гадаад улс тухайн улсын нутаг дэвсгэрт Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, хэм хэмжээний дагуу хамгаалаагүй, эсхүл хамгаалах үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн;

19.1.4.гадаад улсын иргэн, хуулийн этгээдийн хууль бус үйл ажиллагаанаас Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, эдийн засаг, нийтийн ёс суртахуунд хохирол учирсан, эсхүл учруулах бодит эрсдэл үүссэн боловч тухайн улс уг үйл ажиллагааг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хамтран ажиллах талаар олон улсын гэрээ, хамтын ажиллагааны хүрээнд шаардлагатай арга хэмжээг авааагүй.

19.2.Хариу арга хэмжээг олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, хэм хэмжээ, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцүүлэн, хамгаалах зорилгод зайлшгүй шаардлагатай, тохирсон хэмжээнд хэрэгжүүлнэ.

19.3.Худалдааны зөвлөл энэ хуулийн 19.1-т заасан нөхцөл байдлын талаар холбогдох мэдээллийг цуглуулж, үнэлгээ хийж, дүгнэлт гаргана.

19.4.Худалдааны зөвлөл хариу арга хэмжээ авах шаардлагатай гэж дүгнэлт гаргасан тохиолдолд эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн, холбогдох санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлнэ.

19.5.Хариу арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох тухай шийдвэрийг Засгийн газар гаргана.

20 дугаар зүйл.Ачилтын өмнөх шалгалт

20.1.Хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, импортын барааны тоо хэмжээ, чанар, техникийн болон эрүүл ахуйн шаардлагын нийцлийг баталгаажуулах зорилгоор Монгол Улсад импортлох зарим бараанд ачилтын өмнөх шалгалтыг нэвтрүүлж болно.

20.2.Ачилтын өмнөх шалгалтыг бараанд 3 жилээс илүүгүй хугацаагаар нэвтрүүлнэ.

20.3.Ачилтын өмнөх шалгалтыг хэрэглэх хугацааг сунгах эсэхийг шийдвэрлэхдээ уг арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг нэгтгэн дүгнэж, үнэлнэ.

20.4.Ачилтын өмнөх шалгалт хийх барааны жагсаалтыг Засгийн газар батална.

20.5.Бараанд ачилтын өмнөх шалгалт явуулахтай холбоотой зардлыг тухайн барааны импортлогч хариуцна.

20.6.Ачилтын өмнөх шалгалтын байгууллагын эрхийг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

20.7.Ачилтын өмнөх шалгалтын байгууллагыг сонгохдоо дараах шалгуурыг харгалзан үзнэ:

20.7.1.мэргэжлийн нэр хүнд;

20.7.2.техникийн болон хүний нөөц;

20.7.3.ачилтын өмнөх шалгалтын үйлчилгээ үзүүлсэн туршлага;

DRAFT

20.7.4.ачилтын өмнөх шалгалт явуулах зардлын тооцоо.

20.8.Ачилтын өмнөх шалгалт хийх журмыг Засгийн газар батална.

20.9.Ачилтын өмнөх шалгалтын байгууллага энэ хуулийн 22.4-т заасан журмын дагуу худалдаа эрхлэгчээс ирүүлсэн өргөдлийн үндсэн дээр ачилтын өмнөх шалгалтыг явуулж худалдаа эрхлэгчид ачилтын өмнөх шалгалтын гэрчилгээ олгох, эсхүл татгалзах шийдвэр гаргана.

20.10.Ачилтын өмнөх шалгалтад хамрагдсан гэрчилгээг гаалийн байгууллагад ирүүлсэн тохиолдолд тухайн барааг Монгол Улсад импортлохыг зөвшөөрнө.

21 дүгээр зүйл.Гарал үүслийн гэрчилгээ

21.1.Барааны гарал үүслийн гэрчилгээ олгох журмыг эдийн засаг, худалдааны бодлогын болон гаалийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

21.2.Тодорхой барааны гарал үүслийн гэрчилгээ олгох чиг үүргийг холбогдох мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагад шилжүүлж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ, ЭКСПОРТЫГ ДЭМЖИХ

22 дугаар зүйл.Худалдааг дэмжих үндэсний стратеги

22.1.Худалдааг дэмжих үндэсний стратегийг эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулна.

22.2.Худалдааг дэмжих үндэсний стратегийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор тухайн төсвийн жилийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хамт гурван жилд нэг удаа төсвийн тухай хуулийн 8.1-д заасан цаглабарын дагуу Улсын Их Хурал батална.

22.3.Худалдааг дэмжих үндэсний стратегид дараах асуудлыг тусгана:

22.3.1.худалдааны стратегийн зорилт, бүтэц, түүнийг хэрэгжүүлэх арга зам;

22.3.2.Монгол Улсын болон олон улсын худалдааны нөхцөл байдлын шинжилгээ;

22.3.3.худалдаанд нөлөөлөх эрсдэл, тэдгээрийн таамаглал;

22.3.4.Монгол Улсын бусад улс, бүс нутагтай байгуулсан худалдааны хэлэлцээрийн хэрэгжилт;

22.3.5.экспортыг дэмжих арга хэмжээ;

22.3.6.худалдааг хөнгөвчлөх арга хэмжээ.

22.4.Эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Худалдааг дэмжих үндэсний стратегийг боловсруулах талаар бодлогын судалгаа, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг гүйцэтгүүлж болно.

23 дугаар зүйл.Экспортыг дэмжих

23.1.Экспортыг дэмжих зорилгоор төрөөс дотоодын үйлдвэрлэгч, экспортлогч хуулийн этгээдэд дараах дэмжлэг үзүүлнэ:

23.1.1.зах зээл, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн судалгаа хийх;

23.1.2.дэвшилтэт техник, технологи нутагшуулах;

DRAFT

23.1.3.өндөр технологи шингэсэн, өрсөлдөх чадвар бүхий эцсийн бүтээгдэхүүний экспортыг хөгжүүлэх;

23.1.4.гадаад улсад суугаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан экспортын бүтээгдэхүүнийг сурталчлах;

23.1.5.олон улсын худалдааны үзэсгэлэн, яармаг, арга хэмжээнд оролцох, зохион байгуулах;

23.1.6.нийлүүлэлт, борлуулалтын сүлжээ байгуулах, өргөжүүлэх;

23.1.7.үндэсний стандарт боловсруулах, олон улсын стандартад нийцүүлэх, бүртгүүлэх;

23.1.8.экспортын чиглэлийн хүний нөөцийг бэлтгэх;

23.1.9.импортын түүхий эд, туслах материал, тоног төхөөрөмжид татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх;

23.1.10.экспорт, импортын хөнгөлөлттэй зээл олгох, зээлийн хүүгийн татаас үзүүлэх;

23.1.11.экспортын зээлийн батлан даалт, даатгалын үйлчилгээ үзүүлэх.

23.2.Энэ хуулийн 23.1-т заасан санхүүгийн дэмжлэгийг Засгийн газрын холбогдох тусгай сангаар дамжуулан санхүүжүүлнэ.

24 дүгээр зүйл.Гадаад худалдааны цахим нэг цонх

24.1.Цахим нэг цонхны үйл ажиллагааны журмыг Засгийн газар батална.

24.2.Цахим нэг цонхны үйл ажиллагааны журамд дараах асуудлыг тусгана:

24.2.1.мэдээллийн системээр дамжуулан үзүүлэх үйлчилгээ, олгох зөвшөөрлийн төрөл, жагсаалт;

24.2.2.гадаад худалдаанд оролцогч болон мэдээллийн системийн операторын эрх, үүрэг;

24.2.3.гадаад худалдааны цахим нэг цонхоор дамжуулан бүрдүүлэх, хүргүүлэх баримт бичиг, мэдээллийн жагсаалт;

24.2.4.баримт бичиг, мэдээллийг гадаад худалдаанд оролцогч болон бусад этгээдээс хүлээн авах хугацаа, журам;

24.2.5.мэдээллийн системээр үзүүлэх үйлчилгээний төлбөрийн хэмжээ.

24.3.Гадаад худалдааны цахим нэг цонхоор дамжуулан үзүүлэх үйлчилгээний төлбөр тухайн үйлчилгээний өртгөөс хэтрэхгүй байна.

24.4.Гадаад худалдааны цахим нэг цонхны мэдээллийн системийн аюулгүй байдал Кибер аюулгүй байдлын тухай хуулийн шаардлагад нийцсэн байна.

ТАВДУГААР БҮЛЭГ. ЦАХИМ ХУДАЛДАА

25 дугаар зүйл.Цахим худалдааны зохицуулалт

25.1.Хил дамнасан цахим худалдааг энэ хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлнэ.

25.2.Цахим худалдаанд оролцогчид хэрэглэгчийг цахим орчинд таньж, баталгаажуулах аргыг ашиглана.

DRAFT

25.3.Энэ хуулийн 25.2-т заасан арга нь аюулгүй, найдвартай, хэрэглэгчийн хууль ёсны эрхийг хамгаалсан байна.

25.4.Хуульд өөрөөр заагаагүй бол цахим худалдааны системийн дэд бүтцийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байршуулахыг шаардахгүй.

26 дугаар зүйл.Цахим худалдаа эрхлэгч

26.1.Цахим худалдаа эрхлэгч тухайн төрлийн бараа, үйлчилгээний худалдааг эрхлэхэд шаардагдах зөвшөөрөлтэй байна.

26.2.Цахим худалдаа эрхлэгч дараах үүрэгтэй:

26.2.1.хэрэглэгчтэй гэрээ байгуулахын өмнө холбогдох хууль тогтоомж бусад эрх зүйн актад заасны дагуу хэрэглэгчийг таньж, баталгаажуулах;

26.2.2.цахим худалдаанд ашиглах танилт, нэвтрэлтийн хэрэгсэл нь хуульд заасан нууцлал, аюулгүй байдлын шаардлагыг хангах;

26.2.3.мэдээллийг холбогдох хууль тогтоомжид зааснаас бусад зорилгоор ашиглахгүй байх, чандлан нууцлах;

26.2.4.хэрэглэгчтэй байгуулах гэрээнд үйлчилгээний нөхцөлийг ойлгомжтой заасан байх, түүнийг хэрэглэгчид тайлбарлаж өгөх;

26.2.5.үйлчилгээний нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангаагүй буруутай үйлдлийн улмаас учирсан хохирлыг хариуцах;

26.2.6.хэрэглэгчийн мэдээллийг цуглуулах, ашиглах үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангаж ажиллах;

26.2.7.цахим худалдааны үйл ажиллагааг зогсоох тохиолдолд 30-аас доошгүй хоногийн өмнө өөрийн цахим хуудасны нүүр хэсэгт тод харагдахуйц байдлаар холбогдох мэдээллийг байршуулж нийтэд мэдэгдэх;

26.2.8.хэрэглэгчийн сонирхол, худалдан авалтын зуршил зэрэг хувийн шинжид үндэслэн хайлтын үр дүн, санал болгож буй мэдээллийг танилцуулж байгаа тохиолдолд тухайн хэрэглэгчид хувийн шинжид нь суурилаагүй сонголтын хувилбарыг давхар санал болгох;

26.2.9.бараа, үйлчилгээг багцлан худалдах тохиолдолд уг багцын тухай мэдээллийг хэрэглэгчдэд тодорхой, ойлгомжтой байдлаар урьдчилан мэдэгдэх;

26.2.10.цахим нэхэмжлэх, цахим худалдааны холбогдох баримтыг хэрэглэгчид гаргаж өгөх;

26.2.11.хуульд заасан бусад.

26.3.Цахим худалдаа эрхлэгчид хориглох зүйл:

26.3.1.хэрэглэгчээс дэнчин авсан тохиолдолд, дэнчинг буцаан олгох нөхцөл, журмыг тодорхой заах, үндэслэлгүйгээр татгалзахгүй байх;

26.3.2.зохиомол сэтгэгдэл, үнэлгээ ашиглах;

26.3.3.бараа, үйлчилгээг багцлан худалдан авахыг зайлшгүй сонголт болгон тулгах;

26.3.4.хуульд заасан бусад.

DRAFT

27 дугаар зүйл.Цахим худалдааны платформ

27.1.Цахим худалдааны платформ эрхлэгч дараах үүрэгтэй:

27.1.1.цахим худалдааны платформд үйл ажиллагаа явуулах этгээдийн бүртгэл, мэдээллийг баталгаажуулах;

27.1.2.хууль зөрчсөн бараа, үйлчилгээ илэрсэн тохиолдолд холбогдох хууль, журамд нийцүүлэн шуурхай арга хэмжээ авах;

27.1.3.кибер халдлага, зөрчлийн үед дагаж мөрдөх төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх;

27.1.4.платформд нэвтрэх, гарах нөхцөл, бараа, үйлчилгээний чанарын баталгаа, хэрэглэгчийн эрхийн болон хувийн мэдээллийн хамгаалалт, гүйлгээний дүрмийг хэрэглэгчид ойлгомжтой байдлаар платформын үйлчилгээний гэрээнд тусгах;

27.1.5.өөрийн болон тухайн платформыг ашиглаж буй бусад этгээдийн үйл ажиллагааг тодорхой ялган харуулах;

27.1.7.цахим худалдааны платформ, цахим худалдааны нөхцөл, гүйлгээний дүрмийг тогтмол нийтэд ил тод, татан авах боломжтойгоор байршуулж, оруулсан өөрчлөлтийг тухай бүр мэдээлж байх;

27.1.8.оюуны өмчийн эрхийг хамгаалахтай холбоотой хууль, журамд нийцүүлэн үйл ажиллагаа эрхлэх;

27.1.9.бараа, үйлчилгээ, гүйлгээтэй холбоотой мэдээллийг бүрдүүлж, мэдээллийг гүйлгээ дууссанаас хойш 3-аас доошгүй жил холбогдох хуульд нийцүүлэн хадгалах;

27.1.10.эрх бүхий байгууллагын хууль ёсны шаардлагыг биелүүлж, хууль зөрчсөн үйл ажиллагааг таслан зогсоох, шаардлагатай мэдээлэл гаргаж өгөх, хяналт шалгалтад хамтран ажиллах.

27.2.Цахим худалдааны платформын зар сурталчилгаа нь Зар сурталчилгааны тухай хуульд заасан шаардлагад нийцсэн байна.

27.3.Цахим худалдааны платформ эрхлэгч платформоор худалдаж буй бараа, үйлчилгээ хүний амь нас, эрүүл мэндийн аюулгүй байдлын шаардлагыг хангахгүй, эсхүл хэрэглэгчийн хууль ёсны эрхийг зөрчиж байгааг мэдсэн, эсхүл мэдэх ёстой байсан боловч шаардлагатай арга хэмжээ аваагүй бол цахим худалдааны платформоор дамжуулан худалдаа эрхлэгчтэй хамтран хариуцлага хүлээнэ.

27.5.Цахим худалдааны платформ эрхлэгч платформоор худалдаж буй хэрэглэгчийн эрүүл мэндтэй холбоотой бараа, үйлчилгээг худалдахдаа платформоор дамжуулан худалдаа эрхлэгчийн зөвшөөрөл, бичиг баримтыг шалгах, хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлээгүйгээс хэрэглэгчид хохирол учруулсан бол цахим худалдааны платформоор дамжуулан худалдаа эрхлэгчтэй хамтран хариуцлага хүлээнэ.

27.6.Цахим худалдааны платформ эрхлэгч үйлчилгээний нөхцөл, гүйлгээний дүрэм, техникийн аргыг ашиглан платформоор дамжуулан худалдаа эрхлэгчийн үйл ажиллагаа, эрхийг урьдчилан мэдэгдээгүй, эсхүл гэрээний нөхцөлд нийцээгүй байдлаар хязгаарлах, үндэслэлгүй шаардлага тавих, үндэслэлгүй хураамж авахыг хориглоно.

27.7.Цахим худалдааны платформын хэрэглэгч нь дараах эрхтэй:

27.7.1.үнэн зөв, бүрэн, ойлгомжтой мэдээлэл авах;

27.7.2.чөлөөтэй сонголт хийх;

27.7.3.гомдол гаргах, маргаан шийдвэрлүүлэх, хохирлоо нөхөн төлүүлэх;

27.7.4.хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангуулах.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ

28 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

28.1.Улсын Их Хурал худалдааг зохицуулах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.1.1.Худалдааг дэмжих үндэсний стратегийг батлах;

28.1.2.худалдааны эрх зүйн орчныг бүрдүүлэх, худалдааны салбарын хөгжлийг дэмжих, худалдааг хөнгөвчлөхтэй холбогдсон төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох;

28.1.3.Худалдааг дэмжих үндэсний стратегийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайланг хэлэлцэх, худалдааны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих.

29 дүгээр зүйл.Засгийн газрын бүрэн эрх

29.1.Засгийн газар худалдааг зохицуулах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

29.1.1.экспортын бүтээгдэхүүнийг олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

29.1.2.Худалдааг дэмжих үндэсний стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх эх үүсвэрийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл, төсвийн хүрээний мэдэгдэл, улсын төсөвт тусган шийдвэрлүүлэх;

29.1.3.гадаад худалдааны цахим нэг цонхны үйл ажиллагааны журмыг батлах;

29.1.4.хуульд заасан бусад.

30 дугаар зүйл.Эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

30.1.Эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.1.1.Монгол Улсын бусад улс, бүс нутагтай байгуулсан худалдааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

30.1.2.Монгол Улсын бусад улс, бүс нутагтай худалдааны гэрээ, хэлэлцээр байгуулах асуудлыг Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу Засгийн газарт танилцуулах;

30.1.3.Монгол Улсын бусад улс, бүс нутагтай байгуулах худалдааны гэрээ, хэлэлцээрийн хэлэлцээг зохион байгуулах;

30.1.4.Монгол Улсын бусад улс, бүс нутагтай байгуулах худалдааны гэрээ, хэлэлцээрийн олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулах;

30.1.5.гадаад худалдааны статистикийн мэдээлэл, судалгааг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс гаргуулах;

30.1.6.худалдааны төлөөлөгчийг томилох;

DRAFT

30.1.7.хуульд заасан бусад.

31 дүгээр зүйл.Худалдааны зөвлөл

31.1.Худалдааны зөвлөл эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.

31.2.Худалдааны зөвлөл дарга, нарийн бичгийн даргатай байна.

31.3.Худалдааны зөвлөл гааль, татвар, төсөв, санхүү болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон эрдэм шинжилгээ, судалгааны болон төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн 7 гишүүнтэй байна.

31.4.Худалдааны зөвлөлийн дарга нь эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

31.5.Худалдааны зөвлөл ажлын албатай байна.

31.6.Худалдааны зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална.

31.7.Худалдааны зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

31.7.1.Худалдааг дэмжих үндэсний стратегийн хэлэлцээрийн хэрэгжилт, үр нөлөөний талаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, санал, дүгнэлт гаргах;

31.7.2.гаалийн татвар, тарифын зохистой тогтолцоог бүрдүүлэх, гаалийн татварын хувь, хэмжээг оновчтой тогтоох асуудлаар гаргасан дүгнэлтэд үндэслэн санал боловсруулах;

31.7.3.худалдааг хөнгөвчлөх зорилгоор хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал гаргах, хууль тогтоомжийн төсөлтэй урьдчилан танилцах, батлагдахаас өмнө саналаа хүргүүлэх;

31.7.4.Монгол Улсаас бусад улс, бүс нутагтай байгуулах худалдааны хэлэлцээрт санал, дүгнэлт, зөвлөмж өгөх;

31.7.5.худалдааны үйл ажиллагааг зохицуулах бусад хуульд заасан зөвлөл, байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах;

31.7.6.хуульд заасан бусад.

32 дугаар зүйл.Гадаад худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

32.1.Гадаад худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гадаад худалдаа, экспортыг дэмжих талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

32.1.1.худалдааны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, биелэлтийг эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;

32.1.2.энэ хуульд заасан экспортын дэмжлэг олгох үйл ажиллагааг зохион байгуулах;

32.1.3.худалдаа эрхлэгчид зориулсан үндэсний болон олон улсын үзэсгэлэн, яармаг, худалдаа, чуулга уулзалт зохион байгуулах;

32.1.4.худалдааны мэдээллийн санг хариуцах;

32.1.5.Монгол Улсын бусад улс, бүс нутагтай байгуулсан худалдааны гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх, сурталчлах, аж ахуйн нэгжүүдийг мэдээллээр хангах.

33 дугаар зүйл.Худалдааны төлөөлөгч

33.1.Хүлээн авагч улсад суугаа худалдааны төлөөлөгчийн тусгай орон тоо бүхий Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газар Монгол Улсын гадаад худалдааны хууль, эрх зүйн орчин, эдийн засгийн нөхцөл байдал, экспортыг дэмжих хөтөлбөрийг сурталчлах, гадаад худалдаа эрхлэгчийг холбох, дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

ДОЛДУГААР БҮЛЭГ. ХУДАЛДААНЫ СТАТИСТИК, МЭДЭЭЛЛИЙН САН

34 дүгээр зүйл.Худалдааны бүртгэл, статистик мэдээллийн сан

34.1.Монгол Улсын гадаад худалдаанд дүн шинжилгээ хийх, зохицуулалт хийх зорилгоор эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний статистикийн газар, Төв банктай хамтран гадаад худалдааны статистикийн мэдээлэл гаргана.

34.2.Гадаад худалдааны мэдээллийн санд бүрдүүлэх мэдээллийн жагсаалтыг эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

34.3.Худалдаатай холбогдох төрийн болон төрийн бус байгууллага энэ хуулийн 34.2-т заасан мэдээллийг эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал тутамд хүргүүлнэ.

34.4.Худалдааны статистикийг Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн ангиллын код, нэр төрлөөр гаргана.

34.5.Худалдааны статистикийг олон улсын статистикийн болон бусад байгууллагаас гаргасан аргачлалд тулгуурлан боловсруулсан үндэсний аргачлалын дагуу гаргана.

34.6.Энэ хуулийн 34.5-д заасан үндэсний аргачлалыг эдийн засаг, худалдааны бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Үндэсний статистикийн хороо хамтран батална.

НАЙМДУГААР БҮЛЭГ. БУСАД ЗҮЙЛ

35 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

35.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль[7], эсхүл Зөрчлийн тухай хуульд[8] заасан хариуцлага хүлээлгэнэ.

35.2.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль[9], Захиргааны ерөнхий хуульд[10] заасан хариуцлага хүлээлгэнэ.

36 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

36.1.Энэ хуулийг .. оны .. дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

DRAFT